



УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН
ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 04 сарын 23 өдөр

Дугаар 4

Улаанбаатар хот

Шуурхай штабыг татан буулгах тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 27¹ дүгээр зүйлийн 27¹.1.1, 27¹.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улсын онцгой комиссын даргын 2024 оны 10 тушаалаар байгуулагдсан Шуурхай штабыг 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдрөөр тасалбар болгож татан буулгасугай.

2. Шуурхай штабаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх тайлан мэдээллийг 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Улсын онцгой комисст хүлээлгэж өгөхийг Шуурхай штабын дарга, Онцгой байдлын ерөнхий газрын Ажиллагааны удирдлагын газрын дарга (хурандаа А.Дашням)-д даалгасугай.

3. Ой, хээрийн түймэр, шар усны үер, үер зэрэг байгаль цаг уурын гаралтай аюулт гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлж, бэлэн байдлыг хангаж ажиллахыг Онцгой байдлын ерөнхий газрын дарга, Улсын онцгой комиссын орлогч дарга (хошууч генерал Г.Ариунбуян)-д үүрэг болгосугай.

4. Шуурхай штаб татан буугдсантай холбогдуулан Улсын онцгой комиссын даргын "Шуурхай штаб байгуулах тухай" 2024 оны 11 дүгээр 29-ний өдрийн 10 дугаар тушаалыг 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



С.АМАРСАЙХАН